



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/26.

Мандагговь

“Хүүхдийн аюулгүй-цэвэр орчин” сургалт
нөлөөллийн үйл ажиллагаа зохион
байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 14.1.1, 20.5.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Аргачлал зардлын норматив батлах тухай” журмын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн тоглоомын талбайн болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх эрүүл аюулгүй цэвэр орчныг бүрдүүлэх, байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”, Залуучуудын зөвлөл-ийг идэвхижүүлж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхэд аюулгүй-цэвэр орчин” сургалт нөлөөллийн үйл ажиллагааг 2023 оны 03 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хүүхдийн аюулгүй-цэвэр орчин” сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 490,800 (Дөрвөн зуун ерэн мянга найман зуун) төгрөгийг Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3.1 дэх заалтын дагуу Нийгмийн бүлэгт чиглэсэн үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй чанартай зохион байгуулж ажиллахыг Залуучуудын салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Д.Мигар), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Залуучуудын салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мигар)-д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301051

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 23 дугаар сарын 20 ний өдрийн
146 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**“ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ-ЦЭВЭР ОРЧИН” СУРГАЛТ НӨЛӨӨЛЛИЙН
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Д. Мигар

(Залуучуудын салбар зөвлөл, хамтын ажиллагаа
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Г. Мандухай

(Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл
ажиллагаа хариуцсан ажилтан)

Гишүүд:

Ш. Эрдэнэсүвд

(Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

----oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
№126 тоот тушаалын 1 дугаар хавсралт



“ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ-ЦЭВЭР ОРЧИН” СУРГАЛТ НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Хүүхдийн тоглоомын талбайн болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх эрүүл аюулгүй цэвэр орчиныг бүрдүүлэх, байгууллага аж ахуй нэгжийн “Залуучуудын зөвлөл”-ийг идэвхижүүлэх, оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахад оршино.

Хугацаа: 2023 оны 03 дугаар сарын 23- 24-ний өдөр

Оролцогчид: Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчид, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчид

Сургалт нөлөөллийн ажлын хүрээнд хийгдэх ажил:

- Хүүхдийн тоглоомын талбайн эрсдэлийг үнэлэх
- Хүүхдийн тоглоомын талбайн эрсдэлийг арилгаж, засварлах
- Хүүхдийн тоглоомын талбайг угааж, цэвэрлэх
- Залуучуудын зөвлөлтэй байгууллагыг уриалгад нэгдүүлж, чэллэнжид дуудах
- Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдад сургалт зохион байгуулах

Зохион байгуулагч:

- Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Дундговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв

Үр дүн:

- ❖ Байгууллагуудын залуучуудын зөвлөлийг идэвхижүүлж, оролцоог нэмэгдүүлэх
- ❖ Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагаанд арга зүйн зөвлөмж өгч, идэвхжүүлэх
- ❖ Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг танилцуулж, сурталчлах
- ❖ Гэр бүлийн харилцааны сургалт орох

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
121... тоот тушаалын 3 дугаар хавсралт



**“ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ-ЦЭВЭР ОРЧИН” СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ/төгрөг/	Нийт үнэ төгрөг
Суралтын цайны материал					
1	Кофе	ш	60	700	42,000
2	Цай	Хайрцаг	1	11,000	11,000
3	Ёотон	Хайрцаг	2	11,100	22,200
4	Печень	Хайрцаг	5	8,000	40,000
5	Печень/chocorie/	Хайрцаг	7	8,400	58,800
6	Кекс	ш	50	2,000	100,000
7	1 удаагын аяга	ш	100	200	20,000
8	Халбага	Хайрцаг		6,000	6,000
Нийт					300,000
Хэрэглэгдэхүүний зардал					
1	Сандалын прүүс мод	ш	3	18,000	54,000
2	Будаг	ш	2	8,000	16,000
3	10-ын боолт	ш	10	1,000	10,000
4	Өнхрүүш	ш	2	2,000	4,000
5	Будаг шингэлэгч	ш	1	8,000	8,000
6	Зүлгүүр	ш	5	1,000	5,000
7	Гоймон	ш	4	4,000	16,000
8	Чихэр	уут	7	8,500	59,500
9	Бичгийн цаас	ш	1	18,300	18,300
Нийт					190,800
Дүн					490,800